



2024.08.07

# ЭРҮҮЛ МЭНДИЙН СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЭЛ

2024 ОНЫ ЭХНИЙ 7 САРЫН БАЙДЛААР

Улаанбаатар хот

Энэхүү товхимолын дэлгэрэнгүй мэдээллийг  
[www.hdc.gov.mn](http://www.hdc.gov.mn) цахим хуудаснаас татаж харна уу!

Эрүүл мэндийн хөгжлийн төв  
Мэдээлэл, технологийн албанаас эрхлэн гаргав.

Шуудангийн хаяг: 14210 Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, Энхтайвны  
гудамж, 13в байр

E-mail: [admin@hdc.gov.mn](mailto:admin@hdc.gov.mn), [www.hdc.gov.mn](http://www.hdc.gov.mn)

Факс: 976-11-320633

Утас: 7011-1485  
7012-8801

<b>ГАРЧИГ</b>	
<b>ЗУРГИЙН ЖАГСААЛТ</b>	<b>4</b>
<b>ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ</b>	<b>4</b>
<b>ЭРҮҮЛ МЭНДИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД</b>	<b>5</b>
<b>1. ЭХ, ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД</b>	<b>6</b>
1.1. Төрөлт	6
1.2. Хүүхдийн эрүүл мэнд	7
1.3. Эхийн эндэгдэл	8
1.4. Нялхсын эндэгдэл	9
1.5. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	10
<b>2. ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ</b>	<b>11</b>
2.1 Амбулаторийн тусламж үйлчилгээ	11
2.2 Халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийн мэдээлэл	12
2.3 Жирэмсний хяналт	12
2.4 Үр хөндөлт	14
2.5 Түргэн тусламжийн дуудлага	15
2.6 Хэвтэн эмчлүүлэгчдийн тусламж үйлчилгээ	17
<b>3. ХҮН АМЫН НАС БАРАЛТ</b>	<b>18</b>
<b>4. ЭМГЭГ СУДЛАЛЫН ШИНЖИЛГЭЭ</b>	<b>20</b>
<b>5. ХАЛДВАРТ ӨВЧИН</b>	<b>21</b>
5.1. Халдварт өвчний нас баралт	21
5.2. Амьсгалын замын халдварт өвчин	21
5.3. Бэлгийн замаар дамжих халдварт өвчин	22
5.4. Коронавируст халдвар /COVID-19/	23

## **ЗУРГИЙН ЖАГСААЛТ**

Зураг 1. 1 Төрсөн эх, амьд төрсөн нярайн тоо	7
Зураг 1. 2 Эхийн эндэгдэл, 100 000 амьд төрөлтөд	8
Зураг 1. 3 Нялхсын эндэгдэл, 1000 амьд төрөлтөд	9
Зураг 1. 4 Нялхсын эндэгдэл, 1000 амьд төрөлтөд, аймгаар	9
Зураг 1. 5 Перинаталь эндэгдэл, 1000 нийт төрөлтөд, аймгаар	10
Зураг 1. 6 Хүүхдийн эндэгдэл, 1000 амьд төрөлтөд	10
Зураг 1. 7 Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, 1000 амьд төрөлтөд, аймгаар	11
Зураг 2. 1 Жирэмсний эрт хяналтын хувь, аймгаар	13
Зураг 2. 2 Түргэн тусламжийн дуудлагын тоо	16
Зураг 3. 1 Нас баралт, /бодит тоогоор/	18
Зураг 5. 1 Амьсгалын замын халдварт өвчний тохиолдол	22
Зураг 5. 2 Бэлгийн замаар дамжих халдварт өвчний тохиолдол	22
Зураг 5.3 Коронавируст халдварын өвчлөл, /хүйс, насны бүлгээр/	23
Зураг 5. 4 Коронавируст халдвар, аймгаар	23

## **ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ**

Хүснэгт 1. 1 Төрөлт, төрөх үед үзүүлсэн эмнэлгийн тусламж, хувиар	6
Хүснэгт 1. 2 Амьд төрсөн хүүхэд, эхийн тээлтийн хугацаа, хувиар	7
Хүснэгт 1. 3 Тав хүртэлх насны хүүхдийн жингийн мэдээ, хувиар	8
Хүснэгт 2. 1 Эмчийн үзлэг, эмнэлгийн төрлөөр, хувиар	12
Хүснэгт 2. 2 Жирэмсний хяналт, хувиар	13
Хүснэгт 2. 3 Шинээр хяналтад хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийн БЗДХ-ын шинжилгээний үзүүлэлт	14
Хүснэгт 2.4 Үр хөндөлтийн түвшин	15
Хүснэгт 2. 5 Түргэн тусламжийн дуудлага, аймгаар	16
Хүснэгт 2. 6 Стационарын тусламж, үйлчилгээний зарим үзүүлэлтүүд	17
Хүснэгт 3. 1 Осол гэмтэл, гадны шалтгаант нас баралтад эзлэх хувь	19
Хүснэгт 4. 1 Эмгэг судлалын шинжилгээний үзүүлэлт, аймгаар	20
Хүснэгт 5. 1 Халдварт өвчний тохиолдол, нас баралт, төрлөөр	21

## Эрүүл мэндийн статистик үзүүлэлтүүд

/2023, 2024 оны эхний 7 сарын байдлаар/

№	Үзүүлэлт	Нэгж	2023 он	2024 он	Өсөлт бууралт
1	Төрсөн эх	Бодит тоо	38296	33541	-4755
2	Амьд төрсөн хүүхэд	Бодит тоо	38532	33797	-4735
3	Амьгүй төрсөн хүүхэд	Бодит тоо	200	176	-24
		1000 нийт төрөлтөд	5.2	5.2	0.0
4	Эхийн эндэгдэл	Бодит тоо	9	6	-3
		100 000 амьд төрөлтөд	23.4	17.8	-5.6
5	5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл /0-4 нас 364 хоног/	Бодит тоо	591	513	-78
		1000 амьд төрөлтөд	15.3	15.2	-0.1
6	Үүнээс: Нялхсын эндэгдэл /0-364 хоног/	Бодит тоо	488	410	-78
		1000 амьд төрөлтөд	12.7	12.1	-0.6
	Үүнээс: Нярайн эндэгдэл /0-28 хоног/	Бодит тоо	321	250	-71
		1000 амьд төрөлтөд	8.3	7.4	-0.9
	Үүнээс: Нярайн эрт үеийн эндэгдэл /0-6 хоног/	Нялхсын эндэгдэлд эзлэх хувь	65.8	61.0	-4.8
		Бодит тоо	209	164	-45
Нярайн эндэгдэлд эзлэх хувь	Бодит тоо	112	86	-26	
	Нярайн эндэгдэлд эзлэх хувь	34.9	34.4	-0.5	
7	Перинаталь эндэгдэл	Бодит тоо	409	340	-69
		1000 нийт төрөлтөд	10.6	10.0	-0.6
8	Нийт нас баралт	Бодит тоо	10132	10209	77
9	Эмнэлгийн нас баралт	Бодит тоо	3201	3293	92
		Хувь	31.6	32.3	0.7
10	Эмнэлэгт хоног болоогүй нас баралт	Бодит тоо	771	710	-61
		Хувь	24.1	21.6	-2.5
11	Жирэмсний эрт хяналт	Хувь	92.3	92.8	0.5
12	Эмчлэгдсэн хүний тоо	Бодит тоо	610811	606013	-4798
13	Ор хоног	Бодит тоо	4165746	4121139	-44607
14	Халдварт өвчин	Бодит тоо	28231	22143	-6088
		10 000 хүн амд	81.7	63.2	-18.5
15	Амьсгалын замын халдварт өвчин	Бодит тоо	11349	10993	-356
		10 000 хүн амд	32.8	31.4	-1.4
16	Бэлгийн замаар дамжих халдварт өвчин	Бодит тоо	6037	6093	56
		10 000 хүн амд	17.5	17.4	-0.1
17	Гэдэсний халдварт өвчин	Бодит тоо	5367	3965	-1402
		10 000 хүн амд	15.5	11.3	-4.2
18	Зоонозын халдварт өвчин	Бодит тоо	209	94	-115
		10 000 хүн амд	0.6	0.3	-0.3
19	Цусаар дамжих халдварт өвчин	Бодит тоо	135	91	-44
		10 000 хүн амд	0.4	0.3	-0.1
20	Бусад халдварт өвчин	Бодит тоо	5134	907	-4227
		10 000 хүн амд	14.8	2.6	-12.2

# 1. Эх, хүүхдийн эрүүл мэнд

## 1.1. Төрөлт

Улсын хэмжээнд 2024 оны эхний 7 сарын байдлаар 33541 эх төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 4755 төрөлтөөр буюу 12.4 хувиар буурсан байна. Төрөлтийн тоо аймгууд болон Улаанбаатар хотод 25-2174 төрөлтөөр буурсан үзүүлэлттэй байна.

Төрсөн эхчүүдийн 27694 нь буюу 82.6 хувь нь эмчийн хяналтын үзлэгт 6 ба түүнээс дээш удаа хамрагдсан байна. Нийт төрөлтийн 0.3 хувийг гэрийн төрөлт эзэлж байгаа бөгөөд Төв, Говьсүмбэр, Хэнтий, Увс, Ховд, Говь-Алтай, Дорнод, Дархан-Уул, Булган, Хөвсгөл аймгуудад улсын дундажаас 0.1-1.1 хувиар өндөр байна.

2024 оны эхний 7 сарын байдлаар мэс заслын аргаар төрсөн эхчүүд 27.8 хувийг эзэлж байгаа ба 17.3 хувь нь төрөлтийн хүндрэлтэй, 82.7 хувь нь хүндрэлгүй төрсөн байна.

### Хүснэгт 1.1. Төрөлт, төрөх үед үзүүлсэн эмнэлгийн тусламж, хувиар

№	Аймаг/хот	Төрөлтийн эзлэх хувь					20 хүртэлх насны төрөлт	35-аас дээш насны төрөлт
		Аймаг, хотын нэгдсэн эмнэлэг	Хувийн эмнэлэг	Сумын нэгдсэн эмнэлэг	Сумын эрүүл мэндийн төв	Гэртээ		
А	Б	1	2	3	4	5	6	7
1	Архангай	89.5	0.0	0.0	10.2	0.3	4.0	20.1
2	Баян-Өлгий	88.5	0.0	0.0	11.5	0.0	0.9	18.5
3	Баянхонгор	95.8	0.0	0.0	4.1	0.1	3.1	20.3
4	Булган	86.1	0.0	0.0	13.6	0.4	2.2	19.0
5	Говь-Алтай	94.2	0.0	0.0	5.4	0.4	3.2	18.8
6	Говьсүмбэр	99.5	0.0	0.0	0.0	0.5	7.2	16.0
7	Дархан-Уул	99.5	0.0	0.0	0.1	0.4	2.5	24.2
8	Дорноговь	90.4	0.0	8.9	0.5	0.2	5.2	22.2
9	Дорнод	97.6	0.0	0.0	2.1	0.4	4.6	24.7
10	Дундговь	95.3	0.0	0.0	4.7	0.0	7.1	19.5
11	Завхан	61.0	0.0	32.8	6.2	0.0	3.4	22.7
12	Орхон	99.8	0.0	0.0	0.0	0.2	2.8	26.4
13	Өвөрхангай	82.0	0.0	12.6	5.2	0.2	4.9	18.9
14	Өмнөговь	87.5	0.0	0.0	12.5	0.0	4.2	21.5
15	Сүхбаатар	94.9	0.0	0.0	4.8	0.3	4.1	25.2
16	Сэлэнгэ	54.5	0.0	41.1	4.2	0.2	5.6	23.6
17	Төв	84.3	0.0	0.0	14.3	1.4	3.5	24.5
18	Увс	90.1	0.0	0.0	9.5	0.4	2.6	18.0
19	Ховд	91.8	0.0	4.4	3.4	0.4	2.6	18.4
20	Хөвсгөл	88.0	0.0	0.0	11.6	0.4	5.0	19.7
21	Хэнтий	78.1	0.0	13.0	8.4	0.5	4.7	21.9
22	<b>Аймгийн дундаж</b>	<b>88.5</b>	<b>0.0</b>	<b>5.0</b>	<b>6.3</b>	<b>0.3</b>	<b>3.6</b>	<b>21.3</b>
23	Улаанбаатар	93.2	6.5	0.0	0.0	0.3	3.4	26.3
24	<b>Улсын дундаж</b>	<b>91.0</b>	<b>3.5</b>	<b>2.3</b>	<b>2.9</b>	<b>0.3</b>	<b>3.5</b>	<b>24.0</b>

## Зураг 1.1. Төрсөн эх, амьд төрсөн нярайн тоо



## 1.2. Хүүхдийн эрүүл мэнд

2024 оны эхний 7 сарын байдлаар улсын хэмжээнд 33797 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 4735 хүүхдээр буюу 12.3 хувиар буурчээ. Төрөлтийн түвшин 1000 хүн амд 10.0 байна.

Амьд төрсөн хүүхдийн 17444 буюу 51.6 хувь нь хүү, 16353 буюу 48.4 хувь нь охин байна. Төрөх үеийн хүйсийн харьцаа 100 охинд ойролцоогоор 107 хүү ногдож байна.

Амьд төрсөн нийт хүүхдээс 1536 нярай буюу 4.5 хувь нь 2500 грамаас доош жинтэй, 219 тохиолдол буюу 0.6 хувь нь төрөлхийн гажигтай төрсөн байна. Төрсний дараа 1 цагийн дотор хөхөө амласан хүүхдийн эзлэх хувь 96.7 байна. Дутуу төрөлтийн түвшин 1000 амьд төрөлтөд 67.6 байна. Амьгүй төрөлтийн түвшин 1000 нийт төрөлтөд 5.2 байна.

Хүснэгт 1.2. Амьд төрсөн хүүхэд, эхийн тээлтийн хугацаа, хувиар

№	Аймаг/хот	Эхийн тээлтийн хугацаа эзлэх хувь					Төрөлхийн гажигтай төрсөн	2500 гр-аас доош жинтэй төрсөн хүүхэд
		22-28 долоо хоногтой	29-32 долоо хоногтой	33-36 долоо хоногтой	37-41 долоо хоногтой	42 долоо хоногос дээш		
А	Б	1	2	3	4	5	6	7
1	Архангай	0.2	0.3	3.3	96.3	0.0	0.3	3.7
2	Баян-Өлгий	0.1	0.5	3.0	96.5	0.0	0.7	4.6
3	Баянхонгор	0.4	1.3	5.1	93.2	0.0	0.5	4.2
4	Булган	0.0	1.1	3.7	95.2	0.0	1.1	3.7
5	Говь-Алтай	0.0	1.4	7.7	90.9	0.0	0.8	4.4
6	Говьсүмбэр	0.0	0.0	2.6	97.4	0.0	1.5	1.5
7	Дархан-Уул	0.2	0.4	2.6	95.8	1.1	0.4	2.2
8	Дорноговь	0.0	0.8	4.0	95.0	0.2	0.8	3.5
9	Дорнод	0.1	0.6	1.5	97.7	0.0	0.3	2.6
10	Дундговь	0.3	1.2	3.6	95.0	0.0	0.9	3.3
11	Завхан	0.0	0.5	4.6	94.9	0.0	1.2	3.8
12	Орхон	0.5	1.1	5.5	92.8	0.1	0.5	5.5
13	Өвөрхангай	0.0	1.5	4.5	94.0	0.0	0.1	4.6
14	Өмнөговь	0.1	1.0	3.5	95.4	0.0	0.9	4.3
15	Сүхбаатар	0.0	0.8	6.8	92.3	0.0	1.1	3.7
16	Сэлэнгэ	0.0	0.5	3.8	95.6	0.2	0.2	2.9
17	Төв	0.5	0.9	5.3	93.3	0.0	0.2	4.1
18	Увс	0.0	0.3	4.8	94.9	0.0	1.0	3.0
19	Ховд	0.1	0.6	3.7	95.6	0.0	0.3	2.6
20	Хөвсгөл	0.0	0.4	4.6	94.6	0.4	1.0	3.9
21	Хэнтий	1.0	0.6	3.0	95.4	0.0	0.3	4.6
22	<b>Аймгийн дундаж</b>	<b>0.2</b>	<b>0.7</b>	<b>4.1</b>	<b>94.9</b>	<b>0.1</b>	<b>0.6</b>	<b>3.8</b>
23	Улаанбаатар	0.5	1.4	6.4	91.7	0.0	0.7	5.2
24	<b>Улсын дундаж</b>	<b>0.3</b>	<b>1.1</b>	<b>5.3</b>	<b>93.2</b>	<b>0.1</b>	<b>0.6</b>	<b>4.5</b>

2024 оны эхний 7 сарын байдлаар тав хүртэлх насны хүүхдийн өсөлт хөгжлийн хяналтад 1098675 хүүхэд хамрагдсанаас 0.15 хувь нь туранхай, 0.13 хувь нь тураалтай, 0.15 хувь нь өсөлтийн хоцрогдолтой байна.

### Хүснэгт 1.3. Тав хүртэлх насны хүүхдийн жингийн мэдээ, хувиар

№	Аймаг/хот	Бүгд	Жингийн мэдээ			А амин дэм уусан	Д амин дэм уусан	Олон найрлагат бичил тэжээл хэрэглэсэн
			Туранхай	Тураалтай	Өсөлтийн хоцрогдолтой			
А	Б	1	2	3	4	5	6	7
1	Архангай	30504	0.30	0.44	0.30	25.01	42.18	14.99
2	Баян-Өлгий	24826	0.37	0.32	0.10	29.64	23.84	6.64
3	Баянхонгор	44629	0.30	0.44	0.35	19.73	30.71	3.72
4	Булган	13467	0.12	0.12	0.16	32.31	11.62	2.24
5	Говь-Алтай	15081	0.28	0.38	0.86	28.35	39.69	5.01
6	Говьсүмбэр	5887	0.02	0.02	0.02	22.47	15.80	3.07
7	Дархан-Уул	53096	0.18	0.02	0.10	16.50	83.68	1.06
8	Дорноговь	24835	0.10	0.20	0.21	20.86	61.16	1.01
9	Дорнод	34772	0.14	0.15	0.17	22.12	43.93	0.65
10	Дундговь	13528	0.04	0.03	0.02	19.92	44.62	0.55
11	Завхан	24257	0.05	0.03	0.07	24.71	50.88	6.98
12	Орхон	51736	0.18	0.04	0.17	14.19	79.93	0.09
13	Өвөрхангай	26651	0.20	0.16	0.18	31.18	50.84	1.72
14	Өмнөговь	24153	0.36	0.16	0.22	25.31	67.37	1.09
15	Сүхбаатар	11729	0.32	0.09	0.38	32.76	35.30	10.26
16	Сэлэнгэ	26571	0.10	0.03	0.02	27.45	17.38	2.80
17	Төв	12920	0.09	0.08	0.09	35.79	32.10	4.35
18	Увс	36163	0.19	0.32	0.36	20.71	36.74	0.28
19	Ховд	40274	0.12	0.07	0.02	18.18	48.27	0.09
20	Хөвсгөл	34210	0.03	0.06	0.09	29.82	57.04	7.32
21	Хэнтий	12271	0.22	0.06	0.10	27.44	60.07	10.15
22	<b>Аймгийн дундаж</b>	<b>561560</b>	<b>0.18</b>	<b>0.16</b>	<b>0.18</b>	<b>23.15</b>	<b>49.49</b>	<b>3.40</b>
23	Улаанбаатар	537115	0.12	0.09	0.11	14.98	27.21	1.46
24	<b>Улсын дундаж</b>	<b>1098675</b>	<b>0.15</b>	<b>0.13</b>	<b>0.15</b>	<b>19.15</b>	<b>38.60</b>	<b>2.45</b>

### 1.3. Эхийн эндэгдэл

Улсын хэмжээнд 2024 оны эхний 7 сарын байдлаар эхийн эндэгдлийн 6 тохиолдол бүртгэгдэж, 100000 амьд төрөлтөд 17.8 ногдож байна. Сүүлийн 10 жилийн дундажаар 100000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдэл 35.5 байна.

Зураг 1.2. Эхийн эндэгдэл, 100 000 амьд төрөлтөд






### 1.4. Нялхсын эндэгдэл

Улсын хэмжээнд 2024 оны эхний 7 сарын байдлаар нялхсын эндэгдлийн 410 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 12.1 ногдож байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 78 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна. Нялхсын эндэгдлийн 59.3 хувь нь эрэгтэй, 40.7 хувь нь эмэгтэй хүүхэд байна.


Нялхсын эндэгдлийн 61.0 хувийг нярайн эндэгдэл эзэлж байгаа ба 1000 амьд төрөлтөд ногдох нярайн эндэгдэл 7.4 байна. Нярайн эндэгдлийн нийт 250 тохиолдлын 164 буюу 65.6 хувь нь эрт үеийн эндэгдэл, 86 буюу 34.4 хувийг хожуу үеийн эндэгдэл тус тус эзэлж байна.

Зураг 1.3. Нялхсын эндэгдэл, 1000 амьд төрөлтөд




2024 оны эхний 7 сарын байдлаар 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийг аймгуудаар харьцуулбал: Төв (25.3), Завхан (18.8), Говь-Алтай (17.9), Хэнтий (17.6), Хөвсгөл (17.5), Архангай (17.0), Баян-Өлгий (14.3), Увс (13.8), Өвөрхангай (12.8) аймгуудад болон Улаанбаатар хотод (12.2) улсын дундаж үзүүлэлтээс 0.1-13.2 өндөр байна.

Зураг 1.4. Нялхсын эндэгдэл, 1000 амьд төрөлтөд, аймгаар



Нялхсын эндэгдлийг шалтгаанаар авч үзвэл: Перинаталь үеийн эмгэг 57.6 хувь, төрөлхийн хөгжлийн гажиг 16.1 хувь, амьсгалын тогтолцооны эмгэг 8.8 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 1.5. Перинаталь эндэгдэл, 1000 нийт төрөлтөд, аймгаар



### 1.5. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл

Улсын хэмжээнд 2024 оны эхний 7 сарын байдлаар тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 513 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 15.2 ногдож байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 78 тохиолдлоор буурсан байна.

Тав хүртэлх насандаа эндсэн хүүхдийн 297 тохиолдол буюу 57.9 хувь нь эрэгтэй, 216 тохиолдол буюу 42.1 хувь нь эмэгтэй хүүхэд байна. Нийт тохиолдлын 24.8 хувь нь эмнэлгээс гадуур, 75.2 хувь нь эмнэлэгт нас барсан ба үүнээс хоног болоогүй нас баралт 23.2 хувийг эзэлж байна.


Зураг 1.6. Хүүхдийн эндэгдэл, 1000 амьд төрөлтөд



Шалтгаанаар авч үзвэл: Нийт эндэгдлийн 84.7 хувь нь өвчнөөр, 15.3 хувь нь осол, гэмтлийн улмаас эндсэн байна. Перинаталь үед үүссэн эмгэг 46.0 хувь, төрөлхийн хөгжлийн гажиг 14.4 хувь, амьсгалын тогтолцооны эмгэг 9.6 хувийг тус тус эзэлж байна.

Аймгуудаар харьцуулбал: 1000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл Төв (34.5), Хөвсгөл (22.8), Хэнтий (22.4), Говь-Алтай (21.8), Архангай (21.7), Завхан (20.5), Булган (18.3), Увс (18.1), Баян-Өлгий (17.1), Дорноговь (16.7) аймгуудад улсын дундаж үзүүлэлтээс 0.3-19.3 өндөр байна.

Зураг 1.7. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, 1000 амьд төрөлтөд, аймгаар



## 2. ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ

### 2.1. Амбулаторийн тусламж үйлчилгээ

Улсын хэмжээнд 2024 оны эхний 7 сарын байдлаар нийт 13623810 эмчийн үзлэг хийгдсэнээс 24.4 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг, 58.1 хувийг өвчний учир амбулаторт, 7.1 хувийг идэвхитэй хяналтын үзлэг, 10.4 хувийг гэрийн үзлэг тус тус эзэлж байна. Нэг их эмчид ногдох үзлэгийн тоо 910 байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад өвчний учир амбулаторийн үзлэг 3.9 хувиар буурч, идэвхитэй хяналт 1.4, гэрийн үзлэг 1.3, урьдчилан сэргийлэх үзлэг 1.2 хувиар тус тус өссөн байна.

## Хүснэгт 2.1. Эмчийн үзлэг, эмнэлгийн төрлөөр, хувиар

№	Аймаг/хот	Багийн бага эмч	Сумын бага эмч	Сумын эх баригч бага эмч	Сумын их эмч	Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг	Өрхийн эмчийн үзлэг	Бусад
А	Б	1	2	3	4	5	6	7
1	Архангай	15.1	3.1	3.2	21.8	37.7	15.1	4.0
2	Баян-Өлгий	8.1	0.5	3.3	16.5	40.7	25.5	5.3
3	Баянхонгор	11.1	2.4	3.5	13.5	47.9	19.5	2.1
4	Булган	11.5	2.7	4.9	17.3	51.2	8.9	3.4
5	Говь-Алтай	9.5	0.3	3.1	11.2	48.0	20.9	7.0
6	Говьсүмбэр	0.0	0.0	0.4	5.9	55.4	27.2	11.2
7	Дархан-Уул	1.6	0.4	0.8	3.8	35.5	39.1	18.9
8	Дорноговь	5.4	1.9	1.3	25.4	38.8	19.7	7.6
9	Дорнод	3.2	0.7	2.3	10.3	45.5	33.2	4.8
10	Дундговь	7.4	0.2	3.1	18.4	57.8	10.6	2.4
11	Завхан	7.5	1.9	2.4	28.3	34.9	20.4	4.7
12	Орхон	0.0	0.0	0.0	1.4	24.6	46.3	27.7
13	Өвөрхангай	6.8	0.6	2.4	10.6	52.7	22.0	4.9
14	Өмнөговь	4.2	1.1	2.7	13.0	39.8	24.0	15.2
15	Сүхбаатар	6.3	2.0	3.1	16.0	56.7	14.1	1.7
16	Сэлэнгэ	0.4	6.2	4.6	13.3	44.3	23.5	7.7
17	Төв	19.1	3.3	5.9	15.2	42.2	12.1	2.2
18	Увс	8.7	1.4	3.9	16.6	47.7	16.4	5.2
19	Ховд	9.2	0.8	1.8	10.5	46.2	25.7	5.8
20	Хөвсгөл	15.1	3.0	5.2	15.6	27.3	28.5	5.5
21	Хэнтий	3.5	2.0	2.5	28.4	32.5	26.4	4.7
<b>22</b>	<b>Аймгийн дундаж</b>	<b>7.0</b>	<b>1.7</b>	<b>2.8</b>	<b>14.0</b>	<b>40.6</b>	<b>25.4</b>	<b>8.6</b>
23	Улаанбаатар	0.0	0.0	0.0	0.7	21.9	31.9	45.5
<b>24</b>	<b>Улсын дундаж</b>	<b>2.7</b>	<b>0.6</b>	<b>1.1</b>	<b>5.8</b>	<b>29.1</b>	<b>29.4</b>	<b>31.3</b>

## 2.2. Халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийн мэдээлэл

Улсын хэмжээнд 2024 оны эхний 7 сарын байдлаар артерийн гипертензи эрт илрүүлэг үзлэгт 18-аас дээш насны нийт 841911 (39.4%) хүн хамрагдсан бөгөөд 39.0 хувь нь эрэгтэй, 61.0 хувь нь эмэгтэй байна. Үр дүнгийн үзүүлэлтээр нийт үзлэгийн 0.6 хувь нь артерийн гипертензи онош батлагдсан байна. Чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгт 35-аас дээш насны нийт 696945 (51.8%) хүн хамрагдсанаас 38.6 хувь нь эрэгтэй, 61.4 хувь нь эмэгтэй байна. Үр дүнгийн үзүүлэлтээр 0.2 хувьд нь чихрийн шижин өвчний онош батлагдсан байна.

Элэгний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 40-65 насны 187969 (20.6%) хүн хамрагдсанаас 47 тохиолдолд хорт хавдар оношлогдсон байна.

### 2.2.1. Хөх, умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгийн мэдээлэл

Улсын хэмжээнд 2024 оны эхний 7 сарын байдлаар умайн хүзүүний хорт хавдрын эсийн шинжилгээнд суурилсан илрүүлэг үзлэгт зорилтот насны нийт 52089 (23.7%) эмэгтэй хамрагдсан байна. Үр дүнгийн үзүүлэлтээр нийт эсийн шинжилгээний 4.1 хувь нь Пап эерэг буюу эсийн түвшинд өөрчлөлттэй, үүнээс хорт хавдрын шинэ өвчлөлийн 23 тохиолдол бүртгэгдсэн байна.

Хөхний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 291419 эмэгтэй хамрагдсанаас 922 (0.3%) тохиолдол хөхний эмнэлзүйн үзлэгээр эерэг, үүнээс хорт хавдрын шинэ өвчлөлийн тохиолдол бүртгэгдээгүй байна.

### 2.3. Жирэмсний хяналт


Улсын хэмжээнд 2024 оны эхний 7 сарын байдлаар жирэмсний хяналтад шинээр 33796 эмэгтэйчүүд хамрагдсан ба 92.8 хувь нь эхний 3 сартайд, 6.4 хувь нь 4-6 сартайд, 0.8 хувь нь 7 ба түүнээс дээш сартайд хяналтад орсон байна. Хяналтад орсон жирэмсэн эмэгтэйчүүдийн 96.9 хувь нь цусны шинжилгээнд хамрагдсанаас 4.5 хувь нь цус багадалттай байна.

Шинээр хяналтад хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдээс трихомониаз илрүүлэх шинжилгээнд 92.5 хувь, заг хүйтэн илрүүлэх шинжилгээнд 92.4 хувь, тэмбүү илрүүлэх шинжилгээнд 98.7 хувь, ХДХВ/ДОХ илрүүлэх шинжилгээнд 97.7 хувь нь хамрагдсан байна.

#### Хүснэгт 2.2. Жирэмсний хяналт, хувиар

№	Аймаг/хот	Хяналтад авсан хувь			6 ба түүнээс дээш удаа хяналтад хамрагдаж төрсөн	Цус багадалттай жирэмсэн эмэгтэйчүүд
		Эхний 3 сартайд	4-6 сартайд	7 ба түүнээс дээш сартайд		
А	Б	1	2	3	4	5
1	Архангай	93.0	6.1	1.0	74.5	3.5
2	Баян-Өлгий	95.2	4.3	0.4	54.5	8.1
3	Баянхонгор	91.3	8.2	0.5	91.6	5.6
4	Булган	94.9	5.1	0.0	74.0	2.2
5	Говь-Алтай	94.2	4.9	0.9	89.2	0.0
6	Говьсүмбэр	91.6	8.4	0.0	83.0	0.0
7	Дархан-Уул	96.5	3.4	0.1	80.3	12.4
8	Дорноговь	87.3	11.2	1.6	84.3	4.7
9	Дорнод	95.6	4.3	0.1	82.6	3.9
10	Дундговь	96.9	2.5	0.6	92.9	0.0
11	Завхан	91.5	8.2	0.2	91.8	2.6
12	Орхон	99.5	0.5	0.0	77.4	3.0
13	Өвөрхангай	94.1	5.4	0.6	75.2	1.6
14	Өмнөговь	90.7	8.2	1.1	92.6	1.4
15	Сүхбаатар	88.8	10.4	0.7	94.4	2.7
16	Сэлэнгэ	89.4	8.3	2.3	89.1	0.8
17	Төв	92.4	6.6	1.0	90.1	1.3
18	Увс	96.1	3.5	0.3	88.3	1.1
19	Ховд	94.4	5.0	0.6	86.2	2.9
20	Хөвсгөл	91.0	8.4	0.6	68.6	1.5
21	Хэнтий	92.3	6.8	0.9	83.4	1.1
22	<b>Аймгийн дундаж</b>	<b>93.4</b>	<b>6.0</b>	<b>0.7</b>	<b>80.7</b>	<b>3.5</b>
23	Улаанбаатар	92.3	6.8	0.9	84.1	5.3
24	<b>Улсын дундаж</b>	<b>92.8</b>	<b>6.4</b>	<b>0.8</b>	<b>82.6</b>	<b>4.5</b>

Зураг 2.1. Жирэмсний эрт хяналтын хувь, аймгаар



Хүснэгт 2.3. Шинээр хяналтад хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийн БЗДХ-ын шинжилгээний үзүүлэлт

№	Аймаг/хот	Трихомониаз	Үүнээс: Эерэг	Заг хүйтэн	Үүнээс: Эерэг	Тэмбүү	Үүнээс: Эерэг
1	Архангай	550	0	550	0	720	16
2	Баян-Өлгий	918	0	918	0	1370	0
3	Баянхонгор	827	43	827	1	858	15
4	Булган	366	2	367	3	392	3
5	Говь-Алтай	350	0	373	0	440	5
6	Говьсүмбэр	149	3	149	0	149	3
7	Дархан-Уул	1087	11	1087	0	1087	13
8	Дорноговь	659	4	659	1	763	8
9	Дорнод	613	10	613	1	734	20
10	Дундговь	303	0	265	0	320	1
11	Завхан	396	1	396	0	468	1
12	Орхон	969	17	969	2	969	3
13	Өвөрхангай	857	0	857	0	1033	6
14	Өмнөговь	768	14	768	2	836	8
15	Сүхбаатар	521	11	521	0	521	5
16	Сэлэнгэ	683	13	652	2	900	5
17	Төв	508	10	505	0	620	5
18	Увс	646	1	680	3	836	1
19	Ховд	866	0	846	0	918	3
20	Хөвсгөл	932	8	932	10	976	18
21	Хэнтий	513	4	511	0	639	2
<b>22</b>	<b>Аймгийн дүн</b>	<b>13481</b>	<b>152</b>	<b>13445</b>	<b>25</b>	<b>15549</b>	<b>141</b>
23	Улаанбаатар	17779	204	17779	15	17821	277
<b>24</b>	<b>Улсын дүн</b>	<b>31260</b>	<b>356</b>	<b>31224</b>	<b>40</b>	<b>33370</b>	<b>418</b>

## 2.4. Үр хөндөлт

Улсын хэмжээнд 2024 оны эхний 7 сарын байдлаар нийт 6994 эмэгтэйчүүд үр хөндөх мэс ажилбарыг хийлгэсэн байна. Өмнөх оны мөн үеэс 255 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна.

Нийт үр хөндөлтийн 346 тохиолдол буюу 4.9 хувийг хожуу үр хөндөлт, 310 тохиолдол буюу 4.4 хувийг өсвөр насны үр хөндөлт эзэлж байна.

#### Хүснэгт 2.4. Үр хөндөлтийн түвшин

№	Аймаг/хот	Үр хөндөлтийн тоо			Үр хөндөлтийн харьцаа (1000 амьд төрөлтөд)		
		2023 он	2024 он	5 жилийн дундаж	2023 он	2024 он	5 жилийн дундаж
1	Архангай	90	109	137	108.4	168.7	160.8
2	Баян-Өлгий	89	35	59	54.7	23.9	36.9
3	Баянхонгор	47	67	101	48.2	80.0	101.7
4	Булган	32	19	41	86.5	69.6	101.8
5	Говь-Алтай	22	47	37	38.7	93.3	57.5
6	Говьсүмбэр	18	9	25	81.8	46.2	107.3
7	Дархан-Уул	307	243	321	256.9	233.0	269.9
8	Дорноговь	201	194	201	315.5	324.4	279.1
9	Дорнод	90	116	188	98.5	148.5	196.6
10	Дундговь	74	63	64	179.6	186.4	145.0
11	Завхан	7	5	14	10.0	8.6	20.1
12	Орхон	148	137	130	111.3	121.5	96.9
13	Өвөрхангай	89	68	93	76.3	67.2	78.4
14	Өмнөговь	238	271	302	295.7	392.2	366.2
15	Сүхбаатар	60	68	59	80.3	110.7	83.0
16	Сэлэнгэ	25	18	17	32.1	27.2	20.0
17	Төв	37	53	45	72.8	121.8	81.9
18	Увс	136	165	149	125.0	175.7	143.9
19	Ховд	27	28	21	24.0	29.6	19.1
20	Хөвсгөл	21	11	24	16.2	9.6	17.2
21	Хэнтий	33	40	49	43.0	64.0	60.6
<b>22</b>	<b>Аймгийн дүн</b>	<b>1791</b>	<b>1766</b>	<b>2079</b>	<b>99.2</b>	<b>114.2</b>	<b>112.1</b>
23	Улаанбаатар	5458	5228	5298	266.6	285.1	256.4
<b>24</b>	<b>Улсын дүн</b>	<b>7249</b>	<b>6994</b>	<b>7377</b>	<b>188.1</b>	<b>206.9</b>	<b>188.1</b>

#### 2.5. Түргэн тусламжийн дуудлага

Улсын хэмжээнд 2024 оны эхний 7 сарын байдлаар 467095 түргэн тусламжийн дуудлага хүлээн авч үйлчилсэнээс 7.0 хувийг алсын, 10.1 хувийг осол, гэмтлийн дуудлага эзэлж байна.

## Зураг 2.2. Түргэн тусламжийн дуудлагын тоо



## Хүснэгт 2.5. Түргэн тусламжийн дуудлагын тоо

№	Аймаг/хот	Түргэн тусламжийн дуудлага			Бүх дуудлагад эзлэх хувь	Алсын дуудлагын эзлэх хувь	Осол, гэмтлийн дуудлагын эзлэх хувь
		Бүгд	Алсын дуудлага	Осол, гэмтлийн дуудлага			
1	Архангай	9450	2054	435	2.0	21.7	4.6
2	Баян-Өлгий	9640	2264	269	2.1	23.5	2.8
3	Баянхонгор	8407	2011	325	1.8	23.9	3.9
4	Булган	7942	999	239	1.7	12.6	3.0
5	Говь-Алтай	7967	1403	191	1.7	17.6	2.4
6	Говьсүмбэр	2940	118	87	0.6	4.0	3.0
7	Дархан-Уул	9358	229	944	2.0	2.4	10.1
8	Дорноговь	9442	1169	467	2.0	12.4	4.9
9	Дорнод	5754	530	243	1.2	9.2	4.2
10	Дундговь	6042	1267	169	1.3	21.0	2.8
11	Завхан	12381	1804	222	2.7	14.6	1.8
12	Орхон	8912	186	1426	1.9	2.1	16.0
13	Өвөрхангай	10429	2723	505	2.2	26.1	4.8
14	Өмнөговь	5492	920	506	1.2	16.8	9.2
15	Сүхбаатар	9736	2031	206	2.1	20.9	2.1
16	Сэлэнгэ	15819	2388	679	3.4	15.1	4.3
17	Төв	9434	2818	417	2.0	29.9	4.4
18	Увс	8658	2544	182	1.9	29.4	2.1
19	Ховд	7667	1663	296	1.6	21.7	3.9
20	Хөвсгөл	12202	1775	291	2.6	14.5	2.4
21	Хэнтий	12617	1642	254	2.7	13.0	2.0
<b>22</b>	<b>Аймгийн дүн</b>	<b>190289</b>	<b>32538</b>	<b>8353</b>	<b>40.7</b>	<b>17.1</b>	<b>4.4</b>
23	Улаанбаатар	276806	97	38671	59.3	0.0	14.0
<b>24</b>	<b>Улсын дүн</b>	<b>467095</b>	<b>32635</b>	<b>47024</b>	<b>100.0</b>	<b>7.0</b>	<b>10.1</b>



## 2.6 Хэвтэн эмчлүүлэгчдийн тусламж үйлчилгээ

Улсын хэмжээнд 2024 оны эхний 7 сарын байдлаар 606013 үйлчлүүлэгч эмнэлэгт хэвтэн эмчлүүлж, 4121139 ор хоног ашигласан байна. Улсын дунджаар ор ашиглалтын хувь 65.7, дундаж ор хоног 6.8 байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хэвтэн эмчлүүлэгч 4798 хүнээр, ор хоног 44607 тохиолдлоор тус тус буурсан байна.

### Хүснэгт 2.6. Стационарын тусламж, үйлчилгээний зарим үзүүлэлтүүд


№	Аймаг/хот	Орны тоо	Орны фонд ашиглалт	Орны фонд ашиглалтын хувь	Дундаж ор хоног	Орны эргэлт
1	Архангай	594	141.6	66.5	7.0	20.6
2	Баян-Өлгий	1016	148.0	69.5	7.1	21.5
3	Баянхонгор	691	144.8	68.0	6.9	21.1
4	Булган	309	169.7	79.7	7.1	24.1
5	Говь-Алтай	493	131.5	61.7	7.0	18.9
6	Говьсүмбэр	176	147.4	69.2	7.0	21.6
7	Дархан-Уул	843	149.3	70.1	7.0	21.7
8	Дорноговь	549	146.7	68.9	7.1	21.0
9	Дорнод	584	141.1	66.2	6.7	21.1
10	Дундговь	368	131.2	61.6	7.3	18.2
11	Завхан	633	131.9	61.9	6.7	19.8
12	Орхон	941	154.6	72.6	6.8	23.1
13	Өвөрхангай	1044	119.9	56.3	6.9	17.7
14	Өмнөговь	767	87.3	41.0	6.3	13.9
15	Сүхбаатар	530	156.1	73.3	7.9	20.2
16	Сэлэнгэ	878	122.1	57.3	7.1	17.5
17	Төв	565	137.3	64.5	7.2	19.4
18	Увс	562	168.5	79.1	6.7	25.3
19	Ховд	820	158.6	74.4	7.6	21.0
20	Хөвсгөл	1011	120.5	56.6	6.7	18.3
21	Хэнтий	602	157.3	73.9	7.4	21.6
<b>22</b>	<b>Аймгийн дүн</b>	<b>13976</b>	<b>139.2</b>	<b>65.3</b>	<b>7.0</b>	<b>20.1</b>
23	Улаанбаатар	15467	140.7	66.1	6.6	21.5
<b>24</b>	<b>Улсын дүн</b>	<b>29443</b>	<b>140.0</b>	<b>65.7</b>	<b>6.8</b>	<b>20.8</b>

### 3. ХҮН АМЫН НАС БАРАЛТ

2024 оны эхний 7 сарын байдлаар улсын хэмжээнд нас баралтын 10209 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 77 тохиолдлоор өссөн байна.

Нийт нас баралтын 6427 тохиолдол буюу 63.0 хувь нь эрэгтэй, 3782 буюу 37.0 хувь нь эмэгтэй байна. Нийт нас баралтын 32.3 хувь нь эмнэлэгт нас барсан бөгөөд үүнээс 710 тохиолдол буюу 21.6 хувийг хоног болоогүй нас баралт эзэлж байна. Эмнэлэгт хоног болоогүй нас баралт өмнөх оны мөн үеэс 61 тохиолдлоор буурсан байна.

Зураг 3.1. Нас баралт, /бодит тоогоор/



Нас баралтын түвшин 1000 хүн амд 3.0 байна. Нас баралтын 4.0 хувийг нэг хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, 5.0 хувийг тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл эзэлж байна.

Осол гэмтэл, гадны шалтгаант нас баралтын 1742 тохиолдол бүртгэгдэж, нийт нас баралтын 17.1 хувийг эзэлж байна. Өмнөх оны мөн үеэс 32 тохиолдлоор буурсан бөгөөд 10000 хүн амд ногдох осол гэмтэл, гадны шалтгаант нас баралт 5.1 байна.

*Хүснэгт 3.1. Осол гэмтэл, гадны шалтгаант нас баралтад эзлэх хувь*

№	Аймаг/хот	Амиа хорлолт	Бусдад хорлогдсон	Үйлдвэрийн осол	Зам тээврийн осол	Бусад осол	Тодорхойгүй
A	Б	1	2	3	4	5	6
1	Архангай	17.9	1.8	1.8	30.4	48.2	0.0
2	Баян-Өлгий	17.2	0.0	0.0	37.9	44.8	0.0
3	Баянхонгор	35.3	2.9	0.0	26.5	35.3	0.0
4	Булган	22.2	3.7	0.0	18.5	55.6	0.0
5	Говь-Алтай	19.2	3.8	0.0	30.8	46.2	0.0
6	Говьсүмбэр	5.0	0.0	5.0	30.0	60.0	0.0
7	Дархан-Уул	13.6	0.0	4.5	13.6	68.2	0.0
8	Дорноговь	20.0	2.2	0.0	35.6	42.2	0.0
9	Дорнод	20.0	8.6	0.0	14.3	57.1	0.0
10	Дундговь	16.7	0.0	0.0	27.8	55.6	0.0
11	Завхан	34.8	13.0	0.0	30.4	21.7	0.0
12	Орхон	4.8	4.8	0.0	4.8	85.7	0.0
13	Өвөрхангай	20.0	5.7	0.0	22.9	51.4	0.0
14	Өмнөговь	23.1	0.0	0.0	26.9	50.0	0.0
15	Сүхбаатар	14.3	10.7	14.3	28.6	32.1	0.0
16	Сэлэнгэ	23.0	3.3	0.0	24.6	49.2	0.0
17	Төв	14.9	0.0	3.0	38.8	43.3	0.0
18	Увс	34.0	2.1	0.0	29.8	34.0	0.0
19	Ховд	9.5	0.0	0.0	23.8	61.9	4.8
20	Хөвсгөл	40.3	4.2	0.0	20.8	34.7	0.0
21	Хэнтий	28.8	9.6	3.8	15.4	42.3	0.0
<b>22</b>	<b>Аймгийн дундаж</b>	<b>22.6</b>	<b>3.7</b>	<b>1.4</b>	<b>26.0</b>	<b>46.1</b>	<b>0.1</b>
23	Улаанбаатар	11.6	7.7	0.5	5.5	66.8	7.9
<b>24</b>	<b>Улсын дундаж</b>	<b>16.4</b>	<b>5.9</b>	<b>0.9</b>	<b>14.5</b>	<b>57.7</b>	<b>4.5</b>

#### 4. ЭМГЭГ СУДЛАЛЫН ШИНЖИЛГЭЭ

2024 оны эхний 7 сарын байдлаар аймаг хотын нэгдсэн эмнэлгүүдэд нас баралтын 2655 тохиолдол бүртгэгдсэнээс 40.3 хувьд нь эмгэг судлалын болон шүүх эмнэлгийн задлан шинжилгээ хийгдсэн байна.

Задлан шинжилгээний хувь Булган, Өвөрхангай, Дундговь, Баян-Өлгий, Төв, Дархан-Уул, Говьсүмбэр аймгуудад аймгийн дундаж үзүүлэлтээс 5.0-23.3 хувиар доогуур үзүүлэлттэй байна. Улсын хэмжээнд үндсэн оношийн зөрүү 28 тохиолдол бүртгэгдэж, оношийн зөрүүний хувь 3.1 байна.

##### Хүснэгт 4.1. Эмгэг судлалын шинжилгээний үзүүлэлт, аймгаар

№	Аймаг/хот	Эдийн шинжилгээ	Эсийн шинжилгээ	Аймаг, хотын нэгдсэн эмнэлэгт бүртгэгдсэн нас баралт	Аймаг, хотын нэгдсэн эмнэлэгт хийгдсэн задлан шинжилгээ		Аймаг, хотын нэгдсэн эмнэлгийн амьгүй төрөлт	Амьгүй төрөлтөд хийгдсэн задлан шинжилгээ	Задлан шинжилгээ хийгээгүй	Задлан шинжилгээний хувь	Оношийн зөрүү /тоо/	Оношийн зөрүүний хувь
					Эмгэг судлалын	Шүүх эмнэлгийн						
1	Архангай	593	732	37	11	5	1	1	21	44.7%	0	0.0%
2	Баян-Өлгий	472	1741	23	5	0	3	3	18	30.8%	1	12.5%
3	Баянхонгор	1006	2386	40	21	4	3	1	15	60.5%	3	13.6%
4	Булган	251	1860	15	3	3	0	0	9	40.0%	0	0.0%
5	Говь-Алтай	594	1248	23	13	1	2	2	9	64.0%	0	0.0%
6	Говьсүмбэр	138	264	23	2	3	0	0	18	21.7%	0	0.0%
7	Дархан-Уул	962	3526	119	20	7	5	5	92	25.8%	1	4.0%
8	Дорноговь	588	1208	39	20	3	0	0	16	59.0%	3	15.0%
9	Дорнод	706	3228	65	21	8	0	0	36	44.6%	0	0.0%
10	Дундговь	304	1133	24	6	3	1	0	15	36.0%	0	0.0%
11	Завхан	272	827	15	7	2	0	1	6	66.7%	0	0.0%
12	Орхон	1621	1913	69	33	6	3	0	30	54.2%	3	9.1%
13	Өвөрхангай	1030	3613	41	15	1	0	0	25	39.0%	0	0.0%
14	Өмнөговь	87	194	22	8	6	0	0	8	63.6%	0	0.0%
15	Сүхбаатар	589	1569	27	17	4	0	0	6	77.8%	1	5.9%
16	Сэлэнгэ	322	768	25	11	1	1	1	13	50.0%	0	0.0%
17	Төв	1110	1613	51	15	0	0	0	36	29.4%	0	0.0%
18	Увс	1067	2155	31	15	1	1	1	15	53.1%	1	6.3%
19	Ховд	548	540	33	15	0	4	2	18	45.9%	0	0.0%
20	Хөвсгөл	692	3745	55	23	4	5	0	28	45.0%	2	8.7%
21	Хэнтий	352	1492	40	17	4	0	0	19	52.5%	0	0.0%
<b>22</b>	<b>Аймгийн дүн</b>	<b>13304</b>	<b>35755</b>	<b>817</b>	<b>298</b>	<b>66</b>	<b>29</b>	<b>17</b>	<b>453</b>	<b>45.0%</b>	<b>15</b>	<b>4.8%</b>
23	Улаанбаатар	34129	16830	1838	544	159	83	30	1135	38.2%	13	2.3%
<b>24</b>	<b>Улсын дүн</b>	<b>47433</b>	<b>52585</b>	<b>2655</b>	<b>842</b>	<b>225</b>	<b>112</b>	<b>47</b>	<b>1588</b>	<b>40.3%</b>	<b>28</b>	<b>3.1%</b>

## 5. ХАЛДВАРТ ӨВЧИН

Улсын хэмжээнд 2024 оны эхний 7 сарын байдлаар 24 төрлийн 22143 халдварт өвчний тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 63.2 ногдож байна. Өмнөх оны мөн үеэс 6088 тохиолдлоор буюу 10000 хүн амд ногдох өвчлөл 18.5-оор буурсан байна.

10 000 хүн амд ногдох халдварт өвчнийг аймгуудаар харьцуулбал: Дорнод (156.7), Өмнөговь (156.0), Дорноговь (99.0), Баянхонгор (98.7), Төв (87.6), Дархан-Уул (85.0), Говьсүмбэр (76.5), Говь-Алтай (68.5) аймгуудад улсын дундаж үзүүлэлтээс 5.4-93.5 өндөр байна.

### Хүснэгт 5.1. Халдварт өвчний тохиолдол, нас баралт, төрлөөр

№	Халдварт өвчний төрөл	Өвчлөл			Нас баралт		
		2023 он	2024 он	Өсөлт/ Бууралт	2023 он	2024 он	Өсөлт/ Бууралт
1	Амьсгалын замын халдварт өвчин	11349	10993	-356	25	24	-1
2	Бэлгийн замаар дамжих халдварт өвчин	6037	6093	56	3	1	-2
3	Гэдэсний халдварт өвчин	5367	3965	-1402	1	0	-1
4	Зоонозын халдварт өвчин	209	94	-115	3	2	-1
5	Цусаар дамжих халдварт өвчин	135	91	-44	5	7	2
6	Бусад халдварт өвчин	5134	907	-4227	8	2	-6
7	<b>Нийт халдварт өвчин</b>	<b>28231</b>	<b>22143</b>	<b>-6088</b>	<b>45</b>	<b>36</b>	<b>-9</b>


### 5.1. Халдварт өвчний нас баралт

Улсын хэмжээнд 2024 оны эхний 7 сарын байдлаар халдварт өвчний нас баралтын нийт 36 тохиолдол бүртгэгдсэнээс сүрьеэ (24), нярайн бактерт үжил (6), хачигт энцефалит (2), коронавируст халдвар (2), вируст хепатит (1), төрөлхийн тэмбүү (1) тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.

### 5.2. Амьсгалын замын халдварт өвчин

2024 оны эхний 7 сарын байдлаар улсын хэмжээнд амьсгалын замын халдварт өвчний 10993 тохиолдол бүртгэгдэж, нийт халдварт өвчний 49.6 хувийг эзэлж байна. Амьсгалын замын халдварт өвчин өмнөх оноос 356 тохиолдлоор буурсан байна.

**Зураг 5.1 Амьсгалын замын халдварт өвчний тохиолдол**




### 5.3. Бэлгийн замаар дамжих халдварт өвчин

2024 оны эхний 7 сарын байдлаар улсын хэмжээнд бэлгийн замаар дамжих халдварт өвчний 6093 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 27.5 хувийг эзэлж байна. Өмнөх оны мөн үеэс 56 тохиолдлоор өссөн байна.

Бэлгийн замаар дамжих халдварт өвчний 45.8 хувийг тэмбүү, 33.0 хувийг заг хүйтэн, 20.9 хувийг трихомониаз, 0.3 хувийг ХДХВ/ДОХ тус тус эзэлж байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад тэмбүүгийн өвчлөл 422 тохиолдлоор өссөн ба 10000 хүн амд ногдох тэмбүүгийн өвчлөл Өмнөговь (13.0), Говьсүмбэр (11.1), Баянхонгор (9.4), Дорнод (9.3) аймгууд болон Улаанбаатар хотод (10.9) улсын дундаж үзүүлэлтээс 1.3-5.1 өндөр байна.


**Зураг 5.2. Бэлгийн замаар дамжих халдварт өвчний тохиолдол**




## 5.4. Коронавируст халдвар /COVID-19/

2024 оны эхний 7 сарын байдлаар коронавируст халдварын 173 тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 0.5 ногдож байна. Коронавируст халдварын шалтгаант нас баралтын 2 тохиолдол бүртгэгдсэн байна.

Зураг 5.3. Коронавируст халдварын өвчлөл, /хүйс, насны бүлгээр/



Зураг 5.4. Коронавируст халдварын өвчлөл, 10 000 хүн амд



## Эх, хүүхдийн эрүүл мэндийн үзүүлэлт, 2023, 2024 оны эхний 7 сарын байдлаар

Аймаг хот	Төрсөн эх				Амьд төрсөн хүүхэд				Амьгүй төрсөн хүүхэд	
	2023	2024	5 жилийн дундаж		2023	2024	5 жилийн дундаж		2023	2024
			2023	2024			2023	2024		
1. Архангай	829	647	849		830	646	851		4	4
2. Баян-Өлгий	1610	1456	1590		1627	1466	1599		11	7
3. Баянхонгор	967	834	991		976	838	997		3	4
4. Булган	370	273	406		370	273	407		2	2
5. Говь-Алтай	567	500	647		568	504	650		5	2
6. Говьсүмбэр	219	194	230		220	195	231		0	0
7. Дархан-Уул	1197	1042	1184		1195	1043	1191		8	5
8. Дорноговь	634	594	715		637	598	721		2	0
9. Дорнод	907	776	950		914	781	956		8	2
10. Дундговь	409	338	441		412	338	443		0	2
11. Завхан	695	585	711		698	584	715		2	5
12. Орхон	1329	1117	1339		1330	1128	1345		5	5
13. Өвөрхангай	1161	1006	1188		1167	1012	1192		3	2
14. Өмнөговь	805	687	821		805	691	825		5	2
15. Сүхбаатар	744	608	709		747	614	714		4	0
16. Сэлэнгэ	773	661	827		780	662	832		3	3
17. Төв	502	433	547		508	435	549		1	1
18. Увс	1078	929	1033		1088	939	1037		5	1
19. Ховд	1113	941	1113		1124	947	1120		2	5
20. Хөвсгөл	1292	1138	1370		1298	1140	1373		6	7
21. Хэнтий	761	622	798		767	625	803		3	5
<b>АЙМГИЙН ДҮН</b>	<b>17962</b>	<b>15381</b>	<b>18459</b>		<b>18061</b>	<b>15459</b>	<b>18549</b>		<b>82</b>	<b>64</b>
22. Улаанбаатар	20334	18160	20478		20471	18338	20661		118	112
<b>Улсын дүн</b>	<b>38296</b>	<b>33541</b>	<b>38937</b>		<b>38532</b>	<b>33797</b>	<b>39211</b>		<b>200</b>	<b>176</b>



## Эхийн эндэгдэл, 2023, 2024 оны эхний 7 сарын байдлаар

Аймаг хот	Эхийн эндэгдэл /бодит тоо/		Эхийн эндэгдэл /100 000 амьд төрөлтөд/		
	2023 онд	2024 онд	2023 онд	2024 онд	5 жилийн дундаж
1. Архангай	0	0	0.0	0.0	47.0
2. Баян-Өлгий	0	0	0.0	0.0	75.1
3. Баянхонгор	0	0	0.0	0.0	40.1
4. Булган	0	0	0.0	0.0	0.0
5. Говь-Алтай	0	0	0.0	0.0	0.0
6. Говьсүмбэр	0	0	0.0	0.0	0.0
7. Дархан-Уул	0	0	0.0	0.0	0.0
8. Дорноговь	1	0	157.0	0.0	83.2
9. Дорнод	0	0	0.0	0.0	20.9
10. Дундговь	0	0	0.0	0.0	0.0
11. Завхан	0	0	0.0	0.0	28.0
12. Орхон	0	0	0.0	0.0	0.0
13. Өвөрхангай	0	0	0.0	0.0	33.6
14. Өмнөговь	0	0	0.0	0.0	0.0
15. Сүхбаатар	0	1	0.0	162.9	28.0
16. Сэлэнгэ	0	1	0.0	151.1	24.0
17. Төв	0	0	0.0	0.0	72.8
18. Увс	0	0	0.0	0.0	0.0
19. Ховд	0	0	0.0	0.0	71.4
20. Хөвсгөл	0	0	0.0	0.0	58.3
21. Хэнтий	0	0	0.0	0.0	24.9
<b>АЙМГИЙН ДҮН</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>5.5</b>	<b>12.9</b>	<b>32.3</b>
22. Улаанбаатар	8	4	39.1	21.8	52.3
<b>УЛСЫН ДҮН</b>	<b>9</b>	<b>6</b>	<b>23.4</b>	<b>17.8</b>	<b>42.8</b>

## Төрсөн хүүхдийн мэдээ, 2024 оны эхний 7 сарын байдлаар байдлаар

Аймаг хот	Амьд төрсөн хүүхэд					Амьгүй төрөлтийн түвшин /1000 нийт төрөлтөд/	
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Төрөөд 1 цагийн дотор хөхөө амласан хүүхдийн эзлэх хувь	2500 граммаас доош жинтэй төрсөн хүүхдийн эзлэх хувь	2023 онд	2024 онд
1. Архангай	646	340	306	96.7	3.7	4.8	6.2
2. Баян-Өлгий	1466	779	687	99.8	4.6	6.7	4.8
3. Баянхонгор	838	430	408	98.4	4.2	3.1	4.8
4. Булган	273	146	127	94.9	3.7	5.4	7.3
5. Говь-Алтай	504	264	240	99.2	4.4	8.7	4.0
6. Говьсүмбэр	195	106	89	97.4	1.5	0.0	0.0
7. Дархан-Уул	1043	525	518	98.7	2.2	6.7	4.8
8. Дорноговь	598	330	268	97.0	3.5	3.1	0.0
9. Дорнод	781	414	367	99.5	2.6	8.7	2.6
10. Дундговь	338	170	168	99.4	3.3	0.0	5.9
11. Завхан	584	296	288	98.8	3.8	2.9	8.5
12. Орхон	1128	560	568	99.1	5.5	3.7	4.4
13. Өвөрхангай	1012	512	500	98.1	4.6	2.6	2.0
14. Өмнөговь	691	361	330	99.3	4.3	6.2	2.9
15. Сүхбаатар	614	309	305	90.6	3.7	5.3	0.0
16. Сэлэнгэ	662	341	321	91.5	2.9	3.8	4.5
17. Төв	435	236	199	97.9	4.1	2.0	2.3
18. Увс	939	474	465	96.9	3.0	4.6	1.1
19. Ховд	947	491	456	99.3	2.6	1.8	5.3
20. Хөвсгөл	1140	594	546	97.9	3.9	4.6	6.1
21. Хэнтий	625	336	289	98.4	4.6	3.9	7.9
<b>Аймгийн дүн</b>	<b>15459</b>	<b>8014</b>	<b>7445</b>	<b>97.9</b>	<b>3.8</b>	<b>4.5</b>	<b>4.1</b>
22. Улаанбаатар	18338	9430	8908	95.7	5.2	5.7	6.1
<b>Улсын дүн</b>	<b>33797</b>	<b>17444</b>	<b>16353</b>	<b>96.7</b>	<b>4.5</b>	<b>5.2</b>	<b>5.2</b>

## Хүүхдийн эндэгдэл, 2023, 2024 оны эхний 7 сарын байдлаар

Аймаг хот	Нялхсын эндэгдэл				Нялхсын эндэгдэл /1000 амьд төрөлтөд/				5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл				5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл /1000 амьд төрөлтөд/			
	2023 онд		5 жилийн дундаж		2023 онд		5 жилийн дундаж		2023 онд		5 жилийн дундаж		2023 онд		5 жилийн дундаж	
	онд	онд	онд	онд	онд	онд	онд	онд	онд	онд	онд	онд	онд	онд	онд	онд
1. Архангай	7	11	10	8.4	17.0	12.2	13	14	14	15.7	21.7	16.9	20.1	14.2	19.7	15.2
2. Баян-Өлгий	33	21	26	20.3	14.3	16.1	40	25	32	24.6	17.1	20.1	14.2	19.7	15.2	15.2
3. Баянхонгор	10	10	10	10.2	11.9	10.4	13	12	14	13.3	14.3	14.2	14.2	14.2	14.2	14.2
4. Булган	8	2	6	21.6	7.3	14.7	9	5	8	24.3	18.3	19.7	19.7	19.7	19.7	19.7
5. Говь-Алтай	6	9	10	10.6	17.9	16.0	7	11	12	12.3	21.8	19.1	19.1	19.1	19.1	19.1
6. Говьсүмбэр	2	1	1	9.1	5.1	5.2	2	2	2	9.1	10.3	8.7	8.7	8.7	8.7	8.7
7. Дархан-Уул	12	8	13	10.0	7.7	10.8	15	10	16	12.6	9.6	13.1	13.1	13.1	13.1	13.1
8. Дорноговь	10	6	9	15.7	10.0	11.9	12	10	11	18.8	16.7	14.7	14.7	14.7	14.7	14.7
9. Дорнод	4	4	9	4.4	5.1	9.6	7	9	13	7.7	11.5	14.0	14.0	14.0	14.0	14.0
10. Дундговь	3	0	3	7.3	0.0	5.9	6	1	4	14.6	3.0	8.6	8.6	8.6	8.6	8.6
11. Завхан	10	11	13	14.3	18.8	18.2	13	12	16	18.6	20.5	22.7	22.7	22.7	22.7	22.7
12. Орхон	11	10	11	8.3	8.9	7.9	14	10	12	10.5	8.9	9.2	9.2	9.2	9.2	9.2
13. Өвөрхангай	18	13	15	15.4	12.8	12.8	22	14	17	18.9	13.8	14.6	14.6	14.6	14.6	14.6
14. Өмнөговь	6	8	9	7.5	11.6	11.4	6	8	10	7.5	11.6	12.6	12.6	12.6	12.6	12.6
15. Сүхбаатар	3	5	5	4.0	8.1	7.3	8	7	9	10.7	11.4	12.3	12.3	12.3	12.3	12.3
16. Сэлэнгэ	10	7	8	12.8	10.6	9.9	11	9	11	14.1	13.6	13.2	13.2	13.2	13.2	13.2
17. Төв	7	11	9	13.8	25.3	17.1	11	15	15	21.7	34.5	26.6	26.6	26.6	26.6	26.6
18. Увс	9	13	13	8.3	13.8	12.2	14	17	16	12.9	18.1	15.2	15.2	15.2	15.2	15.2
19. Ховд	15	5	15	13.3	5.3	13.0	17	8	18	15.1	8.4	16.3	16.3	16.3	16.3	16.3
20. Хөвсгөл	12	20	20	9.2	17.5	14.4	21	26	26	16.2	22.8	19.2	19.2	19.2	19.2	19.2
21. Хэнтий	8	11	9	10.4	17.6	11.7	11	14	13	14.3	22.4	16.2	16.2	16.2	16.2	16.2
<b>Аймгийн дүн</b>	<b>204</b>	<b>186</b>	<b>225</b>	<b>11.3</b>	<b>12.0</b>	<b>12.1</b>	<b>272</b>	<b>239</b>	<b>291</b>	<b>15.1</b>	<b>15.5</b>	<b>15.7</b>	<b>15.7</b>	<b>15.7</b>	<b>15.7</b>	<b>15.7</b>
22. Улаанбаатар	284	224	248	13.9	12.2	12.0	319	274	287	15.6	14.9	13.9	13.9	13.9	13.9	13.9
